



---

АНУ-ДАХЬ МОРИН ХУУРЫН IV НААДАМ – 2026  
МОРИН ХУУР СОНИРХОГЧДЫН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Зорилго

Морин хуур хөгжмийг сонирхон суралцагчдад өөрсдийн хичээл зүтгэлээ харуулах боломж бүрдүүлэх, ур чадвараа дээшлүүлэх, цаашдын зорилгоо тодорхойлж үргэлжлүүлэн суралцах урам зориг өгөх, Монгол соёлыг сурталчлан морин хуур хөгжмийг түгээн дэлгэрүүлэхэд энэхүү уралдааны зорилго оршино.

2. Хамрах хүрээ

Морин хуур сонирхдог, тоглодог мэргэжлийн бус бүх хүнд нээлттэй. Морин хуур хөгжмөөр мэргэжил эзэмшсэн болон эзэмшиж буй хүмүүст хамаарахгүй болно.

3. Оролцоо

Оролцогчид доор дурдсан ангилал, шатлалд хамрагдаж, удирдамжийн зааврыг чанд мөрдөнө. Уралдаан хасагдах зарчмаар явагдах ба дараагийн шатандаа тэнцээгүй ч наадмын бусад үйл ажиллагаануудад (хамтлагийн тоглолт, гала тоглолт, мастер анги, хэлэлцүүлэг гэх мэт) оролцож болно.

4. Бүртгэл

Бүртгэл цахимаар **2026.01.01 – 2026.02.01** хооронд явагдана.  
Бүртгэлийн хураамж: **\$50** (Ямарч нөхцөлд буцаагдахгүй.). Дутуу болон хоцорсон бүртгэлийг хүлээн авахгүй. Бүртгэлийн линк: <https://forms.gle/uT77mYVwhE8riJiG8>

5. Хугацаа

Оролцогчид, эцэг эх, багш нар дараах хугацааг анхаарна уу:

- ❖ **Бүртгэл:** 2026.01.01 – 2026.02.01
- ❖ **I шат:** 2026.02.15 – 2026.02.21 (цахимаар)
- ❖ **II шат:** 2026.05.09 (өөрийн биеэр)
- ❖ **III шат:** 2026.05.10 (өөрийн биеэр)

6. Байршил

**The Robert and Judi Newman Center for the Performing Arts**  
University of Denver, 2344 East Iliff Avenue, Denver, CO 80208



## 7. Хамтран зохион байгуулагч

Хойд Америк дахь Морин Хуурын Төвөөс зохион байгуулдаг энэхүү 4 дэх удаагийн наадмын хамтран зохион байгуулагчаар Колорадо мужийн Денвер хотын “Ажнай” Морин Хуурын Төв ажиллана.

## II. НАСНЫ АНГИЛАЛ

Морин хуур сонирхогчдын уралдаан дараах таван ангиллаар явагдана:

- ❖ **Бага нас А** (12 нас хүртэлх)
  - АНУ дахь I, II, III наадмуудад оролцож байсан;
  - 3 ба түүнээс дээш жил суралцаж буй;
- ❖ **Бага нас Б** (12 нас хүртэлх)
  - АНУ дахь I, II, III наадмуудад оролцож байгаагүй;
  - 2024 оноос эхлэн суралцаж буй;
- ❖ **Дунд нас А** (13 – 16 нас хүртэлх)
  - АНУ дахь I, II, III наадмуудад оролцож байсан;
  - 3 ба түүнээс дээш жил суралцаж буй;
- ❖ **Дунд нас Б** (2024 оноос эхлэн суралцагчид)
  - АНУ дахь I, II, III наадмуудад оролцож байгаагүй;
  - 2024 оноос эхлэн суралцаж буй;
- ❖ **Насанд хүрэгчид** (17 ба түүнээс дээш нас)

**Анхааруулга:** Бүртгэлийн хүснэгтэд суралцсан хугацааг үнэн зөв бичих шаардлагатай. Хойд Америк дахь Морин Хуурын Төв бүртгэлийн архивтай тулган шалгаж, өмнөх наадмуудад оролцож байсан тоглогчдыг **А** ангилалд хуваарилна.

## III. УРАЛДААНЫ ШАТЛАЛ

Уралдаан **3 шаттай**, хасагдах зарчмаар явагдана. 1-р шатны уралдааныг цахимаар шалгаруулна. 2, 3-р шатны уралдаанууд өөрийн биеэр шүүгчдийн өмнө тоглох хэлбэрээр явагдана.

### НЭГДҮГЭЭР ШАТ

Оролцогч бүр дараах хөтөлбөрийн дагуу **2** зохиол сонгон тоглож, шаардлага хангах дүрс бичлэг явуулна.

- ❖ **Бага нас А, Б ангилал** (Нийт 6 минут)
  - Ардын богино дуу, бэсрэг уртын дуу, **эсвэл** татлага
  - Өөрийн сонгосон Барууны сонгодог болон орчин цагийн Монголын хөгжмийн зохиолчдын нэг бүтээл



❖ **Дунд А, Б ангилал** (Нийт 6 минут)

- Ардын богино дуу, бэсрэг уртын дуу, **эсвэл** татлага
- Өөрийн сонгосон Барууны сонгодог болон орчин цагийн Монголын хөгжмийн зохиолчдын нэг бүтээл

❖ **Насанд хүрэгчид** (Нийт 8 минут)

- Ардын богино дуу, бэсрэг болон айзам уртын дуу, **эсвэл** татлага
- Өөрийн сонгосон Барууны сонгодог болон орчин цагийн Монголын хөгжмийн зохиолчдын нэг бүтээл

**Дүрс бичлэг илгээх хугацаа**

2026.02.15–2026.02.21 хооронд дараах холбоосоор орж “Unlisted” YouTube холбоостой бичлэгээ илгээнэ үү: <https://forms.gle/WetAiqH3cfGkp8bd8>

**I шатны дүн:** 2026.03.01-нд нийтэд зарлагдана.

**Дүрс бичлэгийн шаардлага**

- Бичлэгийг YouTube-д **UNLISTED** тохиргоотой байршуулсан байх.
- Нэршил: **Ангилал –Нэр Овог – Зохиолын нэр** (англи хэлээр).
- Хоёр зохиолыг тус бүр **тусдаа бичлэг** болгосон байх.
- Нэг камераар, хөдөлгөөнгүй нэг цэгээс бичсэн байх.
- Тоглогчийн бүтэн бие, хөгжмийн зэмсэг бүрэн харагдуулах.
- Дүрс бичлэг нь ямар ч засваргүй байх. Засвартай бичлэг уралдаанаас хасагдах үндэслэл болно

**ХОЁРДУГААР ШАТ**

1-р шатнаас шалгарсан оролцогчид 2-р шатанд оролцох бөгөөд оролцогчид доорх хөтөлбөрийн дагуу тус бүр **2** зохиол сонгож тоглоно.

❖ **Бага нас А, Б ангилал** (Нийт 7 минут)

- Ардын богино дуу, бэсрэг уртын дуу, **эсвэл** татлага
- Өөрийн сонгосон Барууны сонгодог болон орчин цагийн Монголын хөгжмийн зохиолчдын нэг бүтээл

❖ **Дунд А, Б ангилал** (Нийт 8 минут)

- Ардын богино дуу, бэсрэг уртын дуу, **эсвэл** татлага
- Өөрийн сонгосон Барууны сонгодог болон орчин цагийн Монголын хөгжмийн зохиолчдын нэг бүтээл

❖ **Насанд хүрэгчид** (Нийт 10 минут)

- Ардын богино дуу, бэсрэг болон айзам уртын дуу, **эсвэл** татлага
- Өөрийн сонгосон Барууны сонгодог болон орчин цагийн Монголын хөгжмийн зохиолчдын нэг бүтээл



## ГУРАВДУГААР ШАТ

2-р шатнаас нийт 21 тоглогчийг 3-р шатанд шалгаруулах ба ангилал бүрээс 4, онооны үзүүлэлтээр 21 дэх тоглогчийг шалгаруулна. Нийт оролцогчид доорх өгөгдсөн хөтөлбөрийн дагуу 2 зохиол сонгож тоглоно.

### ❖ **Бага нас А, Б ангилал** (Нийт 8 минут)

- Ардын богино дуу, бэсрэг уртын дуу, **эсвэл** татлага
- Өөрийн сонгосон Барууны сонгодог болон орчин цагийн Монголын хөгжмийн зохиолчдын нэг бүтээл

### ❖ **Дунд А, Б ангилал** (Нийт 10 минут)

- Ардын богино дуу, бэсрэг болон айзам уртын дуу, **эсвэл** татлага
- Өөрийн сонгосон Барууны сонгодог болон орчин цагийн Монголын хөгжмийн зохиолчдын нэг бүтээл

### ❖ **Насанд хүрэгчид** (Нийт 10 минут)

- Ардын богино дуу, бэсрэг болон айзам уртын дуу, **эсвэл** татлага
- Өөрийн сонгосон Барууны сонгодог болон орчин цагийн Монголын хөгжмийн зохиолчдын нэг бүтээл

## IV. УРАЛДААНЫ ШҮҮЛТ

1. Уралдааныг мэргэжлийн морин хуурчид, хөгжимчид шүүнэ.
2. 2, 3-р шатны уралдааны ерөнхий шүүгч болон нийт 4 шүүгчдийг уралдааны эхний өдөр танилцуулах болно.
3. 1-р шатны уралдааны дүн 2026 оны 3 сарын 1-нд нийтэд зарлагдана. 2, 3-р шатны уралдааны дүнг тухайн уралдаан дууссанаас 1 цагийн дараа нэгтгэн гаргаж танилцуулах болно.
4. Үнэлгээний шалгуур:
  - Арга барил
  - Гүйцэтгэл
  - Тайзны соёл
5. 2, 3-р шатны уралдааны явцад шүүгчдийн саналаар тоглоочыг зогсоох нь шүүгчдийн бүрэн эрх байх болно.
6. Уралдааны явцад тоглоочдын хөг тохиргоог зохион байгуулагч талаас хөглөгч гаргах учир удирдсан багш нар тайз руу гарахгүй.
7. Шүүгчдийн дүгнэлт эцсийнх бөгөөд түүнд хүндэтгэлтэй хандахыг багш, сурагч, эцэг эхчүүд, оролцогчдод сануулж байна!



## V. ШАГНАЛ

1. Ангилал тус бүрт нэг, хоёр, гутгаар болон шагналт байр, гран при нэг, нийт 21 байр шалгаруулж тусгай шагналаар шагнаана.
2. Мөн уламжлал ёсоор Гран При шагналыг МУАЖ Ц. Батчулуун агсны нэрэмжит гран при цом дагалдана. 2026 оны Гран При шаналыг 4-р наадмын ерөнхий ивээн тэтгэгч, төрийн хан хуур урлаач Д.Уламбаяр захиралтай “Хан Хуур” морин хуур урлалын ширэн цартай хуур дагалдана.

## VI. УРАЛДААНЫ ЖУРАМ, НӨХЦӨЛ

1. Тус наадмын хүндэт шагнал болох МУАЖ, морин хуурч Ц.Батчулууны нэрэмжит Гран При шагналыг тухайн наадмын насанд хүрэгчдийн ангилаас шалгарч авсан тохиолдолд тус тоглооч дахин уралдаанд оролцохгүй.
2. Бага болон дунд насны ангилалаас шалгарч авсан тохиолдолд Гран При шагнал дахин олгогдохгүй. Гэвч тус оролцогч насны ангилалдаа үргэлжлүүлэн оролцох ба насны ангилал ахиулан оролцох боломжтой шинэ дүрмийг 4-р уралдаанд тусгаж байна!
3. Зохион байгуулагчид таны бичлэгийг зөвшөөрөлгүйгээр олон нийтэд тараах болон уралдаанаас бусад зорилгоор ашиглахгүй болно.
4. Наадамд өөрийн биеэр ирж оролцохдоо байр, хоол, тээврийн зардлаа оролцогч өөрөө хариуцаж даана.
5. 18 нас хүрээгүй хүүхдүүдийг эцэг эхчүүд болон асран хамгаалагчид нь үргэлж хараа хяналтандаа байлгаж хариуцана.
6. Уралдаан зохион байгуулагчид уралдааны өдрүүдэд болон гала тоглолтын үеэр гарч болзошгүй ямар нэгэн эвдрэл гэмтэл, хулгайн асуудалд хариуцлага үүрэхгүй.
7. Уралдаан зохион байгуулагчид уралдааны үеэр дээр дурдсан уралдааны удирдамж, нөхцлийг зөрчсөн болоод доорхи зөрчлүүдийг гаргасан тохиолдолд хүн бүрийг уралдаанаас хасах, наадмын үйл ажиллагаанд оролцуулахгүй байх бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд:
  - Уралдааны үйл явцад ямар нэг байдлаар нөлөөлөхийг оролдсон бол.
  - Уралдааны үеэр бусдыг үл хүндэтгэн хэрүүл маргаан үүсгэх, бусдыг хэл амаар доромжлох, бусдын биед халдах оролдлого хийсэн бол.
  - Уралдаан, наадмын үеэр согтууруулах, мансууруулах бодис хэрэглэсэн бол.